

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
4 дүгээр хавсралт

Төлөвлөгөөг хянасан:

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
(албан тушаал)

Тэмдэг

Төлөвлөгөө баталсан:

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

Тэмдэг

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025-02-17

Д/д	үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа / I-IV улирлаар/	Хариуцах нэгж/хэлтэс
1	2	3	4	5	6	7	8
Стратеги төлөвлөгөөний эрхэм зорилго: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, нийт хүн амд эзлэх эрүүл дадал хэвшилтэй , идэвхитэй амьдралын хэв маягтай иргэдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх замаар аймгийн хүн амын дундаж наслалтыг улсын зорилтот түвшинд хүргэнэ.							
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ. АРГА ХЭМЖЭЭ							

1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1. Эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлэ, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.							
1.1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр:							
1.1.1	Аймаг, сум, хороо бүрт иргэд эрүүл зөв хооллолт, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх дасгал хөдөлгөөн, иог, бүжиг зэргийг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор ухуулга нөлөөллийн ажлыг зохион байгуулж, үр дүнг үнэлэх	Улс, орон нутгийн төсөв	Илүүдэл жин, таргалалттай иргэдийн эзлэх хувь Эрүүл зөв хооллолттой иргэдийн эзлэх хувь - Жимс, жимсгэний хэрэглээ - Хүнсний ногооны хэрэглээ - Давсны хэрэглээ - Өөх тосны хэрэглээ Идэвхтэй хөдөлгөөн хийх боломжтой хүн амаас хөдөлгөөн хийдэг хүн амын эзлэх хувь (57800)	49.5 18.5 41.7 30.0 10.5 87.2 17.0	40.0 16.0 50.0 50.0 8.0 75.0 60.0	I-IV улирал	НЭМХ
1.1.2	Нийт хүн амд хавдрын эрт үеийн шинж тэмдэг болон анхдагч эрсдэлт хүчин зүйлтэй тэмцэх асуудлаар мэдээлэл сурталчилгааны интервенцийг жилд 2 удаа хийх	Улс, орон нутгийн төсөв	Цуврал интервенцийн тоо	-	4	I-IV улирал	НЭМХ
1.1.3	Геронтологийн кабинетын үйл ажиллагааг сайжруулж, мэргэшсэн хүний нөөцөөр хангах	Улс, орон нутгийн төсөв	Гериатр эмчийн тусламж үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо	943	1050	I-IV улирал	НЭМХ
1.1.4	Эрүүл Монгол хүн, Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах, Эрүүл шүд, Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, Сэтгэцийн эрүүл мэнд арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Улс, орон нутгийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь Шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувь	85 70	90-ээс дээш 75—аас дээш	I-IV улирал	НЭМХ

1.1.5	Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг, үзлэгийг зохион байгуулж, зорилтот бүлгийн хүн амыг хамруулах	Улс, орон нутгийн төсөв	Ургийн гажгийн эрт илрүүлгийн хувь Нярайн эрт илрүүлгийн хувь Сургуульд суурилсан эрт илрүүлгийн хувь Ажлын байран дахь эрт илрүүлгийн хувь Хавдрын эрт илрүүлгийн хувь	-	Гүйцэтгэлээр	II-IV улирал	НЭМХ
1.1.6	Эрт илрүүлэг үзлэг, оношилгооны явц, үр дүнг Аймгийн засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх	Улс, орон нутгийн төсөв	Хурлын шийдвэрийн тоо	-	1	II улирал	НЭМХ
1.1.7	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад халдварт бус өвчин, тэр дундаа зүрх судасны өвчнөөс сэргийлэх, хянах, нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багц МонПэн болон мобайл технологи ашиглан тусламж үйлчилгээ үзүүлж байгаа байдалд хяналт тавьж, шаардлагатай дэмжлэг үзүүлж, ажиллах	Улс, орон нутгийн төсөв	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин 10000 хүн амд Зүрхний шигдээсийн нас баралтын түвшин (0-74 насны 10000 хүн амд)	19.1 2.2	18.1 1.7	I-IV улирал	НЭМХ
1.1.8	Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, утаат болон электрон тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх болон осол	Улс, орон нутгийн төсөв	Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин Санамсаргүй хордох, хорт бодист өртснөөс шалтгаалсан нас баралтын түвшин 10000 хүн амд (Х40-Х49)	0.9 1.3 33.4	0.5 1.0 26.1	I-IV улирал	НЭМХ

	гэмтлээс сэргийлэх (ахуйн орчны осол гэмтэл, уналт, автотээврийн гм)-д анхаарч, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлыг байгуулах		0-5 насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин 10000 хүүхдэд (Т20-Т32) Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин (10000 хүүхдэд, V00-V99)	0.8	0.5			
1.1.9	Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган, эрүүл мэндийн байгууллагыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болоход дэмжлэг үзүүлж, 1-2 сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийг стандартын дагуу шинэчлэн байгуулах	Улс, орон нутгийн төсөв	Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон Эрүүл мэндийн байгууллагын тоо	5	1	I-IV улирал	НЭМХ	
1.1.10	Алслагдсан эрүүл мэндийн төвүүдэд төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нарны болон газрын гүний сэргээгдэх эрчим хүчийг ашиглан, түүхий нүүрсний хэрэглээг зогсоох ажлыг зохион байгуулах	Улс, орон нутгийн төсөв	Түүхий нүүрсний хэрэглээг зогсоосон эрүүл мэндийн байгууллагын тоо	-	7-8	I-IV улирал	НЭМХ	
1.1.11	“Эрүүл мэнд 20/80” хөтөлбөрийн боловсруулж, салбар дундын оролцоотой хэрэгжүүлэх	Улс, орон нутгийн төсөв	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	-	30	II-IV улирал	НЭМХ	
1.1.12	Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгааг хийж, нотолгоонд суурилсан урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	Улс, орон нутгийн төсөв	15-69 насны хүн амын дундах хавсарсан эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын хувь	Эрсдэлгүй	4.3	5.5	II-IV улирал	НЭМХ
				Эрсдэлтэй	66.7	67		
				Өндөр эрсдэлтэй	29	27.5		

1.1.13	“Health school” аймгийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Улс, орон нутгийн төсөв	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	-	30	II-IV улирал	НЭМХ
1.1.13	“Шүд угаах” сум, аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах	Улс, орон нутгийн төсөв	Оролцогчдын тоо	1500	1500	I-IV улирал	НЭМХ
1.1.13	“Эрүүл зан үйл-Амьдралын үнэ цэнэ” Нийгмийн эрүүл мэндийн нөлөөллийн арга хэмжээг салбар дундын оролцоотойгоор бүх сумдад зохион байгуулах	Улс, орон нутгийн төсөв	Ажилласан сумдын тоо	-	19	I-IV улирал	НЭМХ
1.2. Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд бэхжүүлэх чиглэлээр:							
1.2.1	Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнийг тандах илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийг хамруулах арга хэмжээг төрийн ба төрийн бус байгууллага, ажил олгогчидтой хамтран зохион байгуулж, эмчилгээнд хамрагдалт, эмчилгээний үр дүнг улирал бүр хянах	Улс, орон нутгийн төсөв	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин 10000 хүн амд Сүрьеэгийн нас баралтын түвшин 10000 хүн амд Бэлгийн замын халдварт өвчний өвчлөлийн түвшин 10000 хүн амд	5.8 0.1 15.0	3.7 0.0 14.5	I-IV улирал	НЭМХ
1.2.2	Дархлаажуулалтын хамралтыг орон нутгийн түвшинд нэмэгдүүлэх	Улс, орон нутгийн төсөв	В вируст гепатитийн эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь 5-т вакцины 3-р тунгийн хамралтын хувь Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг вакцины 2-р тунгийн хамралтын хувь	99.4 92.4 90.5	100.0 95.2 92.1	I-IV улирал	НЭМХ
1.2.3	Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэн, жирэмсэн үеийн гурвалсан халдвар (ХДХВ, тэмбүү, гепатитын В, С вирус)-ын	Улс, орон нутгийн төсөв	Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь	93.7	94.7	I-IV улирал	НЭМХ

	илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, эмчилгээний дараах хяналт тавьж төрөлхийн тэмбүүгийн тохиолдол гаргахгүй ажиллах						
Зорилт.2. Эрүүл мэндийн байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх, иргэдийг орон нутагтаа өндөр өртөгтэй нарийн мэргэшлийн тусламжийг авах боломжийг бүрдүүлснээр санхүүгийн болон цаг хугацааны хүлээгдэл чирэгдлийг бууруулна.							
2.1. Иргэд жил бүр урьдчилан сэргийлэх цогц үзлэг, шинжилгээнд хамрагдах соёлыг хэвшүүлэх чиглэлээр:							
2.1.1.	Аймгийн “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Улс, орон нутгийн төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	92%	94%	I-IV улирал	ЭТХ, НЭМХ
2.1.2.	Эмч нарын ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулах	Улс, орон нутгийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан хүний тоо	0	1	II -III улирал	ЭТХ
2.1.3.	Алслагдсан, хүн ам ихтэй сумдад эх хүүхэд, дотрын чиглэлээр мэргэшсэн эмч нарыг гэрээгээр ажиллуулах ажлыг зохион байгуулах	Улс, орон нутгийн төсөв	Гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагын тоо Оношилгоо эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	0	1	II -III улирал	ЭТХ
2.1.4.	Чанарын алба, багийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	Улс, орон нутгийн төсөв	Үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоо Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	10/92	12/93%	I-IV улирал	ЭТХ
2.1.5.	УНТЭ-тэй хамтран ажиллах, эмийн чанар, аюулгүй байдал, сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр туршлага судлах ажлыг зохион байгуулах /эрүүл мэндийн байгууллагуудын эм зүйч, ахлах сувилагч нар/	Улс, орон нутгийн төсөв	Хамрагдсан байгууллагын тоо Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хувь	1	4	I-IV улирал	ЭТХ
2.1.6.	Эмнэлгийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилгоор төрөлжсөн мэргэжлийн тусламж	Улс, орон нутгийн төсөв	Үзүүлсэн тусламж үйлчилгээний нэр төрөл, тоо	3	5	I-III улирал	ЭТХ

	үзүүлэх Үндэсний багийг орон нутагт ажиллах нөхцөлийг ханган байр, хоол, унааны зардлыг шийдвэрлэн, дэмжлэг үзүүлж ажиллах						
2.2. Уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлэх чиглэлээр:							
2.2.1.	Аймгийн уламжлалт анагаах ухааны нөлөөллийн багийнхантай уулзалт зохион байгуулж, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх	Улс, орон нутгийн төсөв	Уулзалтад оролцогсдын тоо Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	1 0	2 80%	I-IV улирал	ЭТХ
2.2.2.	Монголын нэгдмэл уламжлалт анагаах ухааны нийгэмлэгтэй хамтран сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг хамтран зохион байгуулах	Улс, орон нутгийн төсөв	Сургалт, хэлэлцүүлгийн тоо	0	2		ЭТХ
2.2.3.	Хануур болон туулга засал, зүү эмчилгээг хийдэг эмнэлгүүдийн тоог нэмэгдүүлэх, эмч мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулж чадавхижуулах	Улс, орон нутгийн төсөв	Эмчилгээний нөр төрөл нэмэгдүүлсэн байгууллагын тоо Мэргэшсэн эмч нарын тоо	2 1	6 7	II -III улирал	ЭТХ
2.2.4.	Арвайхээр суманд уламжлалт анагаах ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд уламжлалт, сэргээн засахын чиглэлээр үнэлгээ хийн, холбогдох зөвлөмжийг хүргүүлж ажиллах /Сидар мед, Агь мамба, Хөх манал, Чинмэнд, Ачтан-Ирээдүй хувийн хэвшлийн эмнэлгүүд/	Улс, орон нутгийн төсөв	Үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоо Зөвлөмжийн тоо	1 1	5 5	II -IV улирал	ЭТХ
2.2.5.	Төрийн болон уламжлалт анагаах ухааны эмнэлгүүдийн эмч нартай хамтран Арвайхээр сумын 3-7 дугаар ангийн сурагчдын өвөрчлөл тогтоох ажлыг эхлүүлэх, зорилтот	Улс, орон нутгийн төсөв	Хамрагдсан сурагчдын тоо Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	0 0	80< 3-4	II, IV улирал	ЭТХ

	бүлэг рүү эрсдлээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх						
2.3.Яаралтай тусламжийн сүлжээг боловсронгуй болгох чиглэлээр:							
2.3.1.	Баруун, зүүн бүсийн сумдад салбар дундын оролцоотой яаралтай болон, лавшруулсан тусламж, үйлчилгээний чиглэлээр бүсчилсэн үзүүлэх сургалт зохион байгуулах	Улс, орон нутгийн төсөв	Сургалтад хамрагдсан СЭМТ-ийн тоо	0	2	II -IV улирал	ЭТХ
2.3.2.	Төрийн албан хаагч нарт амилуулах суурь тусламж үзүүлэх сургалт зохион байгуулж, чадавхжуулах	Улс, орон нутгийн төсөв	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	2	5	II, IV улирал	ЭТХ
2.3.3.	Дэлхийн цусны донорын өдрийг тохиолдуулан нээлттэй өдөрлөг зохион байгуулж хүндэт доноруудыг алдаршуулах	Улс, орон нутгийн төсөв	Оролцогсдын тоо	1	1	III улирал	ЭТХ
2.4. Орчин үеийн дэвшилтэт технологийг нутагшуулах, нэвтрүүлэх чиглэлээр:							
2.4.1	Хархорин сумын нэгдсэн эмнэлэгт КТГ-ын оношилгоог нэвтрүүлэх	Улс, орон нутгийн төсөв	Оношилгоонд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	0	100<	I-IV улирал	ЭТХ
2.4.2.	Хархорин сумын нэгдсэн эмнэлэгт дутуу нярайн ретинопати болон сонсголын скринингийг хөгжүүлэх	Улс, орон нутгийн төсөв	Скрининг оношилгоог хэрэгжүүлсэн хувь	-	30 хувь	I-IV улирал	ЭТХ
2.4.3.	БОЭТ-д хавдарын ангиографийн оношилгоо эмчилгээг өргөжүүлэх	Улс, орон нутгийн төсөв	Оношилгоо шинжилгээнд хамаргдсан хувь	2	3	I-IV улирал	ЭТХ
2.4.4.	Богд, Бат-Өлзий, Хужирт сумдад эх барихын чиглэлээр оношилгоо эмчилгээний шинэ технологи нэвтрүүлэх	Улс, орон нутгийн төсөв	Шинэ технологи нэвтрүүлсэн тоо	0	2	II -IV улирал	ЭТХ
2.5.Эрүүл мэндийн урт хугацааны тусламж үйлчилгээ болох сэргээн засах, сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр:							
2.5.1.	Сувилагч, Эх баригч мэргэжилтний цогц чадамжийг батлах тухай /А-451 2023-12-20/ сургалт зохион байгуулж, үнэлгээ хийх	Улс, орон нутгийн төсөв	Зохион байгуулсан сургалтын тоо	1	1	I-IV улирал	ЭТХ

2.5.2.	Шинэ сувилагчийг дадлагажуулах сургалтын нэгдсэн удирдамж, хөтөлбөр гаргах	Улс, орон нутгийн төсөв	Хөтөлбөрт хамрагдсан сувилагчийн тоо тоо	1	1	I-IV улирал	ЭТХ
2.5.3	БООТ-ийн дотор, хүүхэд, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд сувилахуйн тусламж үйлчилгээний стандарт, удирдамжийн хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийж, арга зүйгээр хангах	Улс, орон нутгийн төсөв	Үнэлгээ хийсэн байгууллагын тоо	8	12	II -IV улирал	ЭТХ
2.6 Эх барих, эмэгтэйчүүд, хүүхдийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр:							
2.6.1.	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд алслагдсан, хүн ам ихтэй 4 суманд эх барих, эмэгтэйчүүд, хүүхэд, дотрын мэргэшсэн болон зөвлөх эмч нарыг гэрээгээр ажиллуулж, үр дүнг тооцох	Улс, орон нутгийн төсөв	Байгуулсан гэрээ Үзүүлсэн тусламжийн тоо Зайн болон газар дээр үзүүлсэн оношилгоо эмчилгээний тоо	- 0 0	4 10-12 20	II -IV улирал	ЭТХ
2.6.2.	“Сэргийлж болох эхийн эндэгдлийг бууруулах перинатал эндэгдлийг тэглэх” төсөлд хамрагдсан сумдын хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах	Улс, орон нутгийн төсөв	Хэрэгжилтийн хувь	10< 58,1	50< 0	II -IV улирал	ЭТХ
2.6.3.	Жирэмсний хяналтын хувь улс, аймгийн түвшингээс бага Хужирт, Богд, Бат-Өлзий Есөнзүйл, Бүрд, Тарагт, Төгрөг сумдын жирэмсний хяналтанд үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр ханган жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэх,	Улс, орон нутгийн төсөв	Жирэмсний хяналтын хувь	93.7	94.7	II -IV улирал	ЭТХ
2.6.4.	Жирэмсэн үеийн гурвалсан халдвар (ХДХВ, тэмбүү, гепатитын В, С, вирус)-ын илрүүлэг шинжилгээний хамрагдалтыг		Илрүүлгийн хувь Эмчлэн эдэгэрүүлсэн хувь	93.7	94.7	I-IV улирал	ЭТХ

	нэмэгдүүлэх, илэрсэн тохиолдолд бүрэн эмчлэх, хяналтанд авах, бэлгийн хавьтагчийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний байдалд хяналт тавьж ажиллах						
2.6.5.	Хүүхдийн яаралтай тусламж, эрэмбэлэн ангилалтын чиглэлээр анхан шатны эмч нарт сургалт зохион байгуулах	Улс, орон нутгийн төсөв	Сургалт зохион байгуулсан тоо Оролцогчдын тоо	1 60	2 70	I улирал	ЭТХ
2.6.6.	Эх, нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг бууруулах чиглэлээр 2024-2025 онд бүртгэгдсэн эхийн ноцтой хүндрэл болон хүүхдийн эндэгдэлд судалгаа хийж, эмнэлзүйн хэлэлцүүлэг, хурлыг ЭХЭМҮТ-тэй хамтран зохион байгуулах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Улс, орон нутгийн төсөв	Эхийн ноцтой хүндрэлийн хувь Хүүхдийн эндэгдлийн хувь	16,3	14,7	II -IV улирал	ЭТХ
2.6.7.	2 хүртэлх насны хүүхдийн гэрийн идэвхитэй эргэлтэнд тандалт судалгаа хийх, цаашид хэрэгжүүлэх ажлын зөвлөмж гарган хэрэгжүүлэх	Улс, орон нутгийн төсөв	Гэрийн идэвхитэй эргэлтийн хувь	-	80%	II -IV улирал	ЭТХ,
2.6.8.	Төрөх тусламж үйлчилгээнд ураг хянах кардиотокографийн ашиглалтыг сайжруулах зорилгоор сумдын их эмч болон эх баригч нарт сургалт зохион байгуулах	Улс, орон нутгийн төсөв	Кардиотокографийн аппаратаар хангагдсан байгууллагын тоо Сургалтын тоо	10<	20<	I-IV улирал	ЭТХ
2.6.9.	“Хүүхэд яагаад эндэв” бүсчилсэн хэлэлцүүлэг зохион байгуулах, эцэг эх асран хамгаалагчдад зоиулсан болон эмч мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах	Улс, орон нутгийн төсөв	Хэлэлцүүлэг Сургалтын тоо	2	4	I-II улирал	ЭТХ
2.6.10.	“Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” зөвлөгөөнийг өвчлөл нас баралт ихтэй сумдад сумдын Засаг	Улс, орон нутгийн төсөв	Оролцогч нарын тоо Гарсан шийдвэрийн тоо	0	30<	II -III улирал	ЭТХ

	дарга нарын оролцоотой бүсчилэн зохион байгуулах						
Зорилт 3.Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдал, худалдан авалт, үнийн бодлогын хэрэгжилтийг хангаж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.							
3.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт, илтод байдлыг хангуулан, эмийн зохистой хэрэглээг төвлөшүүлэх ажлын хүрээнд:							
3.1.1.	Нянгийн тэсвэржилтээс сэргийлэх арга хэмжээнд салбар дундын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ХХААГ, Мал эмнэлгийн газар, Занабазар худалдааны төвийн лабораторитой хамтран хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулж санал дүгнэлтийг үндэслэн салбар дундын хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргаж, үр дүнг тооцох	Улс, орон нутгийн төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	0	50%	II -IV улирал	ЭТХ
3.1.2.	БОЭТ, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Хужирт, Бат-Өлзий сумдад клиникийн эм зүйн чиглэлээр 1-2 шинэлэг ажлыг нэвтрүүлэх, үр дүнг тооцох	Улс, орон нутгийн төсөв	Нэвтрүүлсэн шинэ технологийн тоо	0	4	I-IV улирал	ЭТХ
3.1.3.	БОЭТ-ийн лабораторитой хамтран антибиотикийн хэрэглээний байдалд дүн шинжилгээ хийж цаашид хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх	Улс, орон нутгийн төсөв	Антибиотикийн хэрэглээний хувь	0	30%	I-IV улирал	ЭТХ
3.1.4.	Эмэн эмчилгээний хорооны үйл ажиллагаанд хяналт тавих, тайланг авч дүгнэлт хийх	Улс, орон нутгийн төсөв	Хэрэгжилтийн хувь	0	100%	I-IV улирал	ЭТХ
3.1.5.	Мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийн хадгалалт, хэрэглээ, зарцуулалтад хяналт тавих	Улс, орон нутгийн төсөв	Үнэлгээний тоо Зөрчлийн тоог арилгуулсан хувь	5 0	8 0	I-IV улирал	ЭТХ
Зорилт 4. Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хангалт, нийгмийн баталгааг сайжруулж, эрүүл мэндийн ажилтны чадамжид суурилсан бүтээмжийг тасралтгүй дээшлүүлнэ.							
4.1.	Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хангалт, нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөрийг шинэчлэн батлуулж, хэрэгжүүлэх	Улсын болон орон	Нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөрт хамрагдсан эмч, мэргэжилтэн	43	100	IV-р улирал	УТХ

		нутгийн төсөв					
4.2.	Эрүүл мэндийн чиглэлийн их, дээд сургуулиудтай хамтран ажиллах гэрээг байгуулж, орон нутагт эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг бэлтгэх	Улсын болон орон нутгийн төсөв	Гэрээ байгуулсан сургуулийн тоо	1	2	III-р улирал	УТХ
4.3.	Бүсийн оношилгоо эмчилгээний төв дээр ерөнхий мэргэшил судлалын эмч бэлтгэх резидентийн сургалтыг зохион байгуулах	Улсын төсөв	Ерөнхий мэргэшлийн резидентийн тоо	6	8	III-р улирал	УТХ
4.4.	Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг ажиллангаа суралцан мэргэжил дээшлүүлэх, үндсэн болон төрөлжсөн мэргэшил эзэмших, мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн гадаад, дотоод сургалтад хамруулах болон эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг үе шаттайгаар бэлтгэн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	Улсын болон орон нутгийн төсөв	Гадаад дотоодын сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	168	170-аас доошгүй	I-IV улирал	УТХ
4.5.	“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Улсын болон орон нутгийн төсөв	Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувь	91	90-ээс доошгүй	I-IV улирал	УТХ
4.6.	Эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжинд олон улсын стандартад нийцсэн анализатор, симулятороор шалгалт тохируулга, баталгаажуулалтыг ЭМХТ-өөр хийлгэх ажлыг хэрэгжүүлэх	Улс, орон нутгийн төсөв	Тоног төхөөрөмж баталгаажуулалт ЭМХТ-өөр хийгдсэн байна.	30 хувь	80 хувь	I-IV улирал	УТХ

4.7.	Тоног төхөөрөмжийн засвар, тохиргоо хийх багаж, төхөөрөмжөөр хангагдсан нэгдсэн төвтэй болох	Улс, орон нутгийн төсөв	Тоног төхөөрөмжийн засвар, тохиргоо хийх нэгдсэн төвтэй болсон байна	0	1	I-II улирал	УТХ
4.8.	Засвар тохиргоонд нэн шаардлагтай багаж хэргэсэл - Генератор (олон төрлийн импульс гаргадаг) - Хүчдэл, гүйдэл хэмжигч осциллографи - Гагнуурын аппарат - Хүчилтөрөгчийн урсгал хэмжигч багаж - Тэжээлийн блок (0-30в, 10А) - Цахилгаан точил - Тиски Тестер	Улс, орон нутгийн төсөв	Нэн шаардлагтай багаж хэргэсэлээр хангагдсан байна.	3	8	I-II улирал	УТХ
4.9.	Сум, өрх, багийн эрүүл мэндийн төвүүдийг тоног төхөөрөмжийн мэдээллийг каталогжуулах	Улс, орон нутгийн төсөв	Каталогжуулсан байгууллагын тоо	0	25	I-IV улирал	УТХ
ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРЭГ							
2.1.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллага болон төрийн тодорхой үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх хувийн хэвшлийн этгээдтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлаг болон хэрэглэгчдийг мэдээллээр хангах	Улс, орон нутгийн төсөв	Үнэлгээ хийсэн байгууллагын тоо	4	8	I-IV улирал	ХШҮМХ
2.3.	Эмэгтэйчүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Улс, орон нутгийн төсөв	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь Илэрсэн зөрчил арилгалтын хувь	-	100% 70%	II улирал	

2.4.	Хүүхэд өсвөр үеийн кабинетын үзүүлж буй тусламж үйлчилгээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Улс, орон нутгийн төсөв	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь Хууль сахин мөрдөлтийн хувь	-	100% 90%	II улирал	
2.5.	Эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын үйлдвэр, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага, эмнэлгийн багаж, материалын ариутгалын үйлчилгээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Улс, орон нутгийн төсөв	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь Хууль сахин мөрдөлтийн хувь	-	100% 100%	II улирал	
2.6.	Арга хэмжээ Тусгай зөвшөөрөл сунгуулсан болон шинээр олгосон аж ахуйн нэгжийн мэдээллийг license.mn программд тухай бүрд нь бүртгэх, баяжилт хийх	Улс, орон нутгийн төсөв	license.mn программд бүртгэсэн тоо	-	гүйцэтгэлээр	I-IV улирал	УТХ
2.7.	Арга хэмжээ 2025 онд тусгай зөвшөөрөл сунгуулах байгууллагуудын судалгаа гаргаж мэдээллэх	Улс, орон нутгийн төсөв	Тусгай зөвшөөрөл сунгуулах байгууллагын тоо	-	гүйцэтгэлээр	I-IV улирал	УТХ
2.8.	Арга хэмжээ www.opendata.1313.mn системд Эрүүл мэндийн байгууллагуудын үйлчлүүлэгчдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх	Улс, орон нутгийн төсөв	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо	1071	2000-аас доошгүй	I-IV улирал	УТХ
2.8.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн тайланд ХШҮ хийж, дээд шатны байгууллагуудад тайлагнах	Улсын төсөв	Журам зааврын дагуу хугацаанд нь тайлагнасан тайлангийн хувь	100.0	100.0	I-IV улиралд	ХШҮМХ
2.9.	Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээний шалгуур үзүүлэлтийн биелэлтийг үнэлэн хагас бүтэн жилээр тайлагнах,	Улсын төсөв	ХШҮ-ний дүгнэлт зөвлөмжийн тоо	2	2	II-IV улирал	ХШҮМХ
2.10.	Аймгийн Засаг даргаас Сумдын Засаг дарга нартай байгуулсан	Улсын төсөв	Зөвлөмжийн тоо	4	4	I-IV улиралд	ХШҮМХ

	гэрээний биелэлтийг улирал бүр дүгнэн зөвлөмжөөр ханган ажиллах						
2.11.	Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссын үйл ажиллагааг идэвхжүүлэх, дотоод хяналт хийж тухай бүр арга хэмжээ авч ажиллах	Улсын төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90.0	100.0	I-IV улиралд	ХШҮМХ
2.10.	Цахимжилт,кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлын талаар Аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлүүлэх	Улсын төсөв	Шийдвэрлэсэн асуудлын тоо	-	1-2	II улиралд	ХШҮМХ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР.